

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ЦАХИМ ИЛ ТОД БАЙДЛЫН ИНДЕКС

2021

Мониторингийн тайлан

2022.03.01



Тайлан боловсруулсан

Хүрэлчулуун Баярмаа

Ахлах судлаач

Баянбат Шинэцэцэг

Зохицуулагч, Судлаач

Мэдээлэл цуглуулагч

Пүрэвдорж Цэдэн-Иш

Мэдээлэл цуглуулалт

Буд Батхүү

Мэдээлэл цуглуулалт

Найдансүрэн Нандинцэцэг

Мэдээлэл цуглуулалт

Олдох Энхтуул




Мэдээлэл цуглуулалт

Тогтохдорж Пүрэвдулам

Мэдээлэл цуглуулалт

“Төрийн байгууллагын цахим хуудасны ил тод байдлын индекс 2021: Мониторингийн тайлан”-г IRIM судалгааны хүрээлэн өөрсдийн санаачилгаар 10 дах жилдээ хийж гүйцэтгэв.

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ЦАХИМ ХУУДАСНЫ ИЛ ТОД БАЙДАЛ СУДАЛГААНЫ ӨМНӨХ ТАЙЛАНГУУД



* Зураг бүр дээр дарж тайлан тус бүртэй танилцах боломжтой. Нийт тайлан: <http://irim.mn/web-monitoring>

АГУУЛГА

Агуулга	4
Удиртгал	5
Арга зүй	6
Индексийн зорилго, зорилт	6
Индексийн бүтэц, арга зүй	6
Цахим ил тод байдлын индексийн онооны тайлбар	8
Үр дүн	
Нэгдсэн үр дүн	9
Бүрэлдэхүүн тус бүрийн үр дүн	9
Төрийн байгууллагын мэдээллийг ил тод болгох эрх зүйн орчны нөхцөл байдал	9
Байгууллагын чадамжийн үр дүн	10
Цахим нээлттэй байдал	12
Төрийн байгууллагын цахим хуудасны ил тод байдлын өөрчлөлт	15
Байгууллагуудын үр дүн	16
Яамдын цахим ил тод байдал	17
Хэрэгжүүлэгч агентлагуудын цахим ил тод байдал	19
Тохируулагч агентлагуудын цахим ил тод байдал	20
Аймгийн ЗДТГ-уудын цахим ил тод байдал	21
Дүүргийн ЗДТГ-уудын цахим ил тод байдал	22
Парламентын харьяа байгууллагуудын цахим ил тод байдал	23
Дүгнэлт, зөвлөмж	24
Хавсралт. Нийт үнэлсэн төрийн байгууллагуудын эрэмбэ	26

УДИРТГАЛ

Ил тод байдал нь сайн засаглалыг төлөвшүүлэхэд чухал үүрэгтэй бөгөөд сайн засаглалыг илэрхийлэх шинж байдлын нэг гэж олон улсын байгууллагууд тодорхойлдог. Үүнийг цахим шилжилтийн үйл явцтай хослуулан хөгжүүлж буй өнөө үед “цахим ил тод байдал” гэх ойлголт бий болсон. Цахим ил тод байдлыг тогтвортой хэрэгжүүлснээр авлигатай тэмцэх, засаглалыг сайжруулах, төр-иргэд болон бусад оролцогч талуудын үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх боломжтой юм. Тодруулбал, төр олон нийтэд үйл ажиллагаагаа нээлттэй хүргэснээр иргэд цаг тухайд нь үнэн зөв мэдээллийг авч, төрийн үйл ажиллагааг үр ашигтайгаар хянаж, төр засагт хариуцлага тооцоход суралцана. Тиймээс төрийн мэдээллийг ил тодоор олон нийтэд хүргэх нь нэн тэргүүний шаардлагатай, чухал асуудал юм.

Монгол Улсын Засгийн Газар 2021-2024 оны үйл ажиллагааныхаа хөтөлбөрт “Цахим үндэстэн” болох зорилт тавьж, үүнд ихээхэн анхаарал хандуулан ажиллаж байна. Уг ажил E-Mongolia төрийн цахим нэгдсэн үйлчилгээгээр дамжин төрийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах, иргэдэд ойртох, төрийн байгууллагын хүнд суртал, авлигыг бууруулж, ил тод байдлыг сайжруулахад чиглэсэн алхмуудыг авч хэрэгжүүлж, олон улсад туршлагаа хуваалцаж байна. Үүнтэй зэрэгцээд цахим засаглалтай холбоотой эрх зүйн орчныг бүрдүүлж, дараагийн түвшинд гаргахын тулд багц хуулийн төслүүд боловсруулж, хууль батлагдах эцсийн шатандаа шилжиж байна. Энэхүү цахим шилжилтийн өөрчлөлтөд COVID-19 цар тахлын улмаас үүсэж буй нөхцөлүүд нөлөөлж буй нь зайлшгүй.

IRIM судалгааны хүрээлэн 2010 оноос хойш 10 дахь удаагаа хийж ирсэн “Төрийн байгууллагын цахим хуудасны ил тод байдал”-ын үнэлгээг 2019 онд олон улсын түвшний индекс болгон хэмжих боломжтой аргагүйгээр шинэчлэн нэг түвшин ахиулсан билээ. Гэвч COVID-19 цар тахлын нөхцөл байдлын улмаас 2020 онд хуучин аргагүй

болох цахим хуудасны ил тод байдлыг хэмжиж, үр дүнгээ тооцсон. Харин энэхүү 2021 оны үр дүн нь 2019 онд боловсруулсан “Цахим ил тод байдлын индекс”-ийг тооцох аргагүйгээр судалсан хоёр дахь удаагийн тайлан юм. Тиймээс тайланд ашиглагдаж буй үр дүнгүүд 2019 оны үр дүнгүүдтэй харьцуулагдаж байна. Арга зүйн ялгааг товчхон дурдвал 2018 оноос өмнө “Төрийн байгууллагын цахим хуудасны ил тод байдлын үнэлгээ”-г хувиар тооцон гаргадаг байв. Ингэхдээ шалгуур үзүүлэлт бүрийг хэдэн хувьтай биелүүлснээс хамаарч төрийн байгууллагын цахим хуудасны ил тод байдлыг “Хаалттай”, “Зарим талаар ил тод”, “Ил тод”, “Бүрэн ил тод” гэсэн 4 түвшингээр үнэлж ирсэн. 2019 оноос “Цахим ил тод байдлын индекс” болгон аргагүйг шинэчилсэн нь зөвхөн цахим хуудасны ил тод байдлыг хэмжихээс гадна бодлогын орчин, тухайн төрийн байгууллагын чадавхыг мөн харгалзан үзэж, “Сайн”, “Хангалттай”, “Сул”, “Хангалтгүй”, “Муу” гэсэн 5 түвшинд үнэлдэг болсон.

Мөн энэхүү үнэлгээ нь Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуульд тулгуурласан аргагүйгээр үнэлэгддэг ба тус хуулийн шинэчилсэн найруулга Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль болж гарч буй энэ шилжилтийн эхлэлтэй давхцаж байна. Тиймээс бид тайлангийн ерөнхий үр дүнгийн хэсэгт өнгөрсөн 10 жилийн үнэлгээний үр дүнгээ харьцуулан та бүхэнд хүргэж байна. Энэхүү үнэлгээг төрийн байгууллагуудын цахим хуудас хэрхэн сайжирч, эсвэл хэрхэн муудаж буйг тоон утга харгалзуулан жил жилээр үнэлэх, мөн өөр хооронд нь харьцуулж болохуйцаар эрэмбэ тогтоон цахим хуудасны мэдээллийг тогтмол сайжруулахад нь хөшүүрэг болох үндсэн зорилготойгоор хийж хэрэгжүүлсээр ирлээ. Уг үнэлгээний үр дүнг төрийн байгууллага өөрсдийн болон бусад төрийн байгууллагуудаас суралцах, цахим мэдээлэл түгээхэд гарч буй ололт ба бэрхшээлийг тодорхойлох, энэ чиглэлээр баримталж буй бодлого, стратегийг сайжруулахад ашиглахыг санал болгож байна.

АРГА ЗҮЙ

Индексийн зорилго, зорилт

Цахим ил тод байдлын индексийн зорилго нь төрийн байгууллагуудын цахим мэдээллийн нээлттэй, ил тод байдлыг үнэлж, тоон үзүүлэлтээр хэмжин, цаашид сайжруулахад хувь нэмэр оруулах явдал юм. Цахим ил тод байдлын индексээр цахим хэрэгслээр нээлттэй хүргэж буй мэдээллийн хэмжээ, цар хүрээ, чадавхыг үнэлнэ.

Ач холбогдлын хувьд уг индекс нь төрийн байгууллагын цахим засаглалыг бүхэлд нь үнэлдэг цор ганц индекс юм. Индексийн зорилтууд нь:

- Төрийн байгууллагуудын цахим ил тод байдлын түвшнийг хэмжиж, эрэмбэлэх
- Үр дүнг өмнөх жилүүдтэй харьцуулах
- Цаашид сайжруулахад чиглэсэн санал, зөвлөмж боловсруулах юм.

Индексийн бүтэц, арга зүй

Цахим ил тод байдлын индекс нь нэгдмэл нэг оноогоор илэрхийлэгдэх бөгөөд 3 бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд авч үздэг. Эдгээр 3 бүрэлдэхүүн нь эрх зүйн орчин, байгууллагын чадамж, цахим нээлттэй байдал гэсэн хэсгээс бүрдэх бөгөөд өөр өөр эх сурвалжуудыг ашиглан 9 дэд бүлэг, 26 индикаторын дагуу үнэлдэг.

ЗУРАГ 1

Цахим ил тод байдлын индексийн бүтэц



1. Эрх зүйн орчин – Уг бүрэлдэхүүн хэсэг нь тухайн улс орны мэдээллийн ил тод байдлын эрх зүй, бодлогын орчныг үнэлдэг. Төрийн байгууллагын мэдээлэл ил тод, нээлттэй байхад бодлого, засаглалын орчин чухал нөлөөтэй. Тиймээс төрийн байгууллагын мэдээлэл ил тод, нээлттэй болгох нөхцөлийг бодлогын түвшинд хэрхэн хангаж буй талаар судалдаг. Түүнчлэн иргэний нийгмийн оролцоо ямар түвшинд байгааг авч үзнэ. Үүнийг хууль, бодлогын баримт бичгүүд болон холбогдох олон улсын үзүүлэлтүүдэд тулгуурлан үнэлнэ. Энэ хэсгийн үнэлгээ нь байгууллагын түвшинд ижил жингээр тооцогддог.

2. Байгууллагын чадамж – Уг бүрэлдэхүүн хэсэг нь тухайн төрийн байгууллагад мэдээллийг ил тод болгох механизм, чадавх хэр бүрдсэн эсэхийг үнэлдэг. Хууль, бодлогоор тогтоосон ил тод байдлыг хангахын тулд төрийн байгууллагуудын i) мэдээлэл ил тод болгох процедур бүрдсэн эсэх, ii) хүний нөөц хүрэлцээтэй эсэх, iii) нээлттэй мэдээллийн санг үүсгэх, авч явах чадавх бий эсэх, iv) технологийн чадавх зэргийг тухайн байгууллагын цахим ил тод байдлыг хариуцсан албан хаагчаас авсан мэдээлэлд тулгуурлан үнэлдэг. Ингэснээр мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлэх, түүнийг хэрэгжүүлэхэд тулгарч буй асуудлуудыг тодорхойлох, цаашид сайжруулах арга замыг тодорхойлох ач холбогдолтой.

3. Цахим нээлттэй байдал – Энэ бүрэлдэхүүн хэсэгт цахим хэрэгслээр нээлттэй хүргэж буй мэдээллийн цар хүрээг үнэлдэг. Нийт 45 үзүүлэлттэй ба үүнийг задалбал технологи 6, нээлттэй мэдээллийн агуулга 36, иргэдийн оролцоо ба харилцааны талаарх 4 асуулттай байна. Эдгээр асуултуудын 80% нь Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль болон бусад холбогдох хууль, дүрэм, стандарттай нийцэж байгаа эсэх буюу мэдээллийн агуулгад тулгуурлах ба үлдсэн 20% нь цахим хуудсыг ашиглахад хялбар байдал, харилцах боломжууд зэрэг технологийн хэрэглээг үнэлдэг.

Цахим ил тод байдлын индекс нь дээрх 3 бүрэлдэхүүн хэсгийн нийлбэрээр тодорхойлогдоно. Индексийг тооцохдоо дээрх 3 бүрэлдэхүүн хэсэг тус бүр ижил жинтэй буюу “1/3” байхаар тооцсон. Бүрэлдэхүүн хэсэг бүр 3 дэд бүлгүүдэд хуваагдаж байгаа ба эдгээр бүлэгт багтах индикаторуудын тооноос хамааран жинг тооцоолно. Жишээлбэл, Цахим нээлттэй байдал бүрэлдэхүүн хэсэг 45 үзүүлэлтээс Технологийн нийцтэй байдал дэд бүлгийн хувьд 3 үзүүлэлтээс бүрдэж байгаа учир 0.065 (3/45) жинтэй байна. Хэрвээ индикатор доторх асуултын тоо өөрчлөгдвөл дээр аргаар жинг хувааж тооцоолно. Цахим ил тод байдлын индекс нь төрийн байгууллагын цахим засаглалыг бүхэлд нь үнэлж буй хамгийн тогтвортой индекс бөгөөд олон улсын түвшинд ч ашиглаж болохуйц арга зүйгээр боловсруулсан.

Цахим ил тод байдлын индексийн онооны тайлбар

Индекс нь 0-ээс 1-ийн хооронд утга авах бөгөөд индексийн утга 1 рүү дөхөх тусам төрийн байгууллагуудын цахим ил тод байдал сайн, харин 0 рүү ойртох тусам хангалтгүй байгааг харуулна. Цахим ил тод байдлын индексийн үр дүнгийн утгыг доорх зурагт нэгтгэн харууллаа.

ЗУРАГ 2

Үр дүнгийн утгын ангилал

Сайн	≥0.80	Цахим ил тод байдлыг бий болгох, мэдээллийг цахимаар нийтлэх процедур, нөөц, хариуцлагыг бүрэн бэхжүүлсэн.
Хангалттай	0.65-0.79	Байгууллага мэдээллийг цахимаар нийтлэх процедур, нөөц, хариуцлагыг бэхжүүлж байгаа.
Сул	0.50-0.64	Цахим ил тод байдлыг бий болгох, сайжруулахтай холбоотой зарим үзүүлэлт байгаа. Цаашид байгаа мэдээллүүдийг шинэчлэх, тогтвортой хангах чадавхыг бэхжүүлэх шаардлагатай.
Хангалтгүй	0.35-0.49	Байгууллагад мэдээллийг цахимаар нийтлэх талаар суурь түвшний процедур, нөөц, хариуцлагатай, ил тод байдлыг цаашид тогтвортой хангах чадвар хомс байна.
Муу	<0.35	Байгууллагад мэдээллийг цахимаар нийтлэх процедур, нөөц, хариуцлага бараг байхгүй, энэ нь эргээд цахим хуудсаар мэдээллийг түгээхгүй байхад гол нөлөө үзүүлж байгаа.

ҮР ДҮН

Нэгдсэн үр дүн

Төрийн болон орон нутгийн захиргааны 6 төрлийн 88 төрийн байгууллагын ил тод байдлын 2021 цахим ил тод байдлын ерөнхий индекс улсын хэмжээнд 0.602 гарсан нь төрийн байгууллагуудын цахим ил тод байдал сул түвшинд байгааг харуулж байна. Уг үр дүнг 2019 онтой харьцуулахад (0.612) өөрчлөлтгүй хэвээр байна. Байгууллагуудын хэдэн хувь нь ил тод байдлын аль түвшинд байгааг доорх зурагт харуулав.

Үнэлгээнд хамрагдсан 88 байгууллагаас 25 хувь буюу 25 байгууллага л ил тод байдал нь 'хангалттай' түвшинд байсан бөгөөд энэ жилийн хувьд "сайн" түвшинд үнэлэгдсэн байгууллага байгаагүй. Нийт байгууллагын талаас дээш хувь нь болох 54 байгууллага "сул" түвшинд үнэлэгджээ. Үлдсэн байгууллагуудын 9 нь "хангалтгүй" түвшинд үнэлэгдсэн бөгөөд муу түвшинд үнэлэгдсэн байгууллага байгаагүй. Хэдийгээр муу түвшинд үнэлэгдсэн байгууллага байхгүй хэдий ч нийт байгууллагын талаас илүү хувьд нь сул түвшинд үнэлэгдсэн, сайн түвшинд үнэлэгдсэн байгууллага байхгүй нь цаашид цахим ил тод байдлыг нэмэгдүүлэх шаардлагатайг харуулж байна.

Бүрэлдэхүүн тус бүрийн үр дүн


Төрийн байгууллагын мэдээллийг ил тод болгох эрх зүйн орчны нөхцөл байдал

Эрх зүйн орчны бүрэлдэхүүн хэсгийн үнэлгээгээр 3 дэд бүлгийн 11 индикаторыг хамруулан үнэлдэг. Уг үнэлгээний үр дүнд эрх зүйн орчин 0.631 оноо буюу 'сул' түвшинд үнэлэгдсэн бөгөөд энэ нь 2019 онд хийгдсэн үнэлгээнээс 0.026 оноогоор буурсан үзүүлэлт юм. Дэд бүлэг тус бүрээр нь задлан харвал 2019 оны үнэлгээнээс дэд бүлэг бүр бууралттай гарсан байна.

- Мэдээллийн ил тод байдал, мэдээлэл авах эрхийн эрх зүйн орчинтой холбоотой мэдээлэл авах эрхийн индикаторууд бусад бүлгүүдтэй харьцуулахад харьцангуй сайн үнэлгээтэй байна. Тэдгээрээс мэдээллийн цар хүрээний үзүүлэлт 2019 оноос буурсан бол бусад индикаторуудад өөрчлөлт гараагүй байна.
- Засаглалын дэд бүлэг хангалтгүй түвшинд байгаа бөгөөд эрх зүйн орчны бүрэлдэхүүн хэсэг дотроо хамгийн бага оноотой байна. Дэлхийн Банкны "Дэлхийн засаглалын индекс"-ийн 2020 оны үнэлгээний 4 бүрэлдэхүүн хэсгийн дүнгээр тооцоологдсон уг оноо 2019 оноос бүх бүрэлдэхүүн хэсгийн хувьд буурсан

ЗУРАГ 3

Байгууллагуудын ил тод байдлын түвшинд эзлэх хувь



- Сүүлийн дэд бүлэг болох иргэний нийгмийн индикаторууд ерөнхийдөө хангалттай түвшинд байна. Иргэдийн оролцоо, иргэний нийгмийн төлөв байдал сул, 2019 оны үнэлгээнээс буурсан үзүүлэлттэй байна. 2019 онтой харьцуулахад эрх зүйн орчны нийт 11 индикатораас иргэний нийгмийн бүрэлдэхүүн хэсэгт багтах хэвлэл мэдээллийн эрх чөлөөний төлөв байдал ганцхан өссөн дүнтэй гарчээ.

Эрх зүйн орчны бүрэлдэхүүн хэсгийг ерөнхийд нь дүгнэхэд ихэнх үзүүлэлт 2 жилийн өмнөхөөс бага зэрэг буурсан боловч мэдэгдэхүйц түвшинд биш байна. Энэ нь цахим ил тод байдлын чиглэлээр хэрэгжүүлж буй суурь бодлогуудад томоохон өөрчлөлт ороогүйтэй холбоотой. Гэвч ирэх жилүүдэд цахим ил тод байдлын чиглэлээрх хууль, бодлогын баримт бичгүүд шинэчлэгдэж байгаатай холбоотойгоор өөрчлөлтүүд бий болох нь дамжиггүй.

Байгууллагын чадамжийн үр дүн

Байгууллагын чадамжийн бүрэлдэхүүн хэсгийн үнэлгээг төрийн байгууллагуудын мэдээллийн ил тод байдал хариуцсан албан хаагчаас авсан судалгааны үр дүнд үндэслэн тооцдог. Нийт үнэлгээнд хамрагдсан 88 байгууллагаас 70 байгууллага нь уг үнэлгээний асуумжийг бөглөжээ. Мэдээллийн ил тод байдлыг хариуцсан мэргэжилтнүүд нь гол төлөв мэдээлэл, технологийн чиглэлийн мэргэжилтэн болон олон нийттэй харилцах, мэдээллийн ажилтан байх нь түгээмэл байна. Зарим тохиолдолд ялангуяа агентлагуудын хувьд улсын байцаагч болон мэргэжилтнүүд мэдээллийн ил тод байдлыг хариуцах нь нийтлэг байна.

ХҮСНЭГТ 1

Эрх зүйн орчны үзүүлэлт

#	Үзүүлэлтүүд	2021	2019	Зөрүү
Мэдээлэл авах эрх		0.267	0.274	-0.007
1	Мэдээлэл авах эрх	1.00	1.00	0
2	Мэдээллийн хүрээ	0.917	0.833	0.084
3	Мэдээлэл хүсэх процедур	0.750	0.750	0
4	Мэдээллийн санц ба хамгаалалт	0.625	0.625	0
Засаглал		0.163	0.172	-0.009
5	Хуулийн хэрэгжилт	0.430	0.463	-0.033
6	Дуу хоолой ба хариуцлага	0.610	0.640	-0.03
7	Зохицуулалтын чанар	0.450	0.493	-0.043
8	Засгийн газрын үр нөлөөтэй байдал	0.470	0.473	-0.003
Иргэний нийгэм		0.523	0.591	0.068
9	Иргэдийн оролцоо	0.670	0.673	-0.003
10	Хэвлэл мэдээллийн эрх чөлөө	0.730	0.721	-0.009
11	Иргэний нийгмийн төлөв байдал	0.400	0.500	-0.1
Хууль эрх зүйн орчны үр дүн		0.631	0.657	-0.026

***Үр дүнгийн онооны тайлбар:** Үр дүн нь 0-ээс 1-ийн хооронд утга авах бөгөөд индексийн утга 1 рүү дөхөх тусам төрийн байгууллагуудын цахим хуудасны ил тод байдал сайн, харин 0 рүү ойртох тусам хангалтгүй байгааг харуулна.

ХҮСНЭГТ 2

Байгууллагын чадамжийн үзүүлэлт

#	Үзүүлэлтүүд	2019	2021	Зөрүү
Байгууллагын бэлэн байдал		0.715	0.713	-0.002
1	Ил тод байдлыг хангах процедур ба процесс	0.813	0.838	0.025
2	Нөөцийн хүрэлцээ	0.618	0.588	-0.03
Үүрэг хариуцлага		0.519	0.485	-0.034
3	Манлайлал	0.642	0.533	-0.109
4	Тасралтгүй хөгжил ба сургалт	0.396	0.437	0.041
Мэдээлэл, холбооны технологи (МХТ)-ийн бэлэн байдал		0.751	0.683	-0.068
5	МХТ-ийн ашиглалт	0.700	0.691	-0.009
6	МХТ-ийн хүрэлцээ	0.742	0.677	-0.065
7	Мэдээллийн сан үүсгэх ашиглах чадвар	0.811	0.680	-0.131
Цахим ил тод байдлын үр дүн		0.661	0.627	0.034

Байгууллагын чадамжийн үзүүлэлтийг 3 бүлэг, 7 индикаторын хүрээнд үнэлэхэд 2021 онд 0.627 оноогоор 'сул' түвшинд үнэлэгдэж байна. Үүнийг 2019 оны байгууллагын чадамжийн үзүүлэлттэй харьцуулахад бага зэрэг буурсан байна. Үүнд байгууллагын үүрэг хариуцлагатай холбоотой үзүүлэлт 'хангалтгүй' түвшинд үнэлэгдсэн нь хамгийн их нөлөөлжээ. Нарийвчилж үзвэл байгууллагын мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлэх чиглэлээр сургалтуудад хамрагдах байдал өмнөх жилтэй харьцуулахад нэмэгдсэн ч сул үзүүлэлттэй (0.407) хэвээр байна. Мөн гадаад, дотоод үнэлгээ дээр тулгуурлан цахим ил тод байдлыг сайжруулах үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх байдал хамгийн сул (0.400) байгаа нь мэдээллийн ил тод байдал нэмэгдэхгүй байхад хамгийн ихээр нөлөөлж байна. Үр дүнгээс харахад мэдээллийг ил тод болгох талаар хууль, дүрэм, журам батлагдаад 10 жил болсон тул мэдээллийн ил тод байдлыг хангах процедур, хүний нөөцийн болон технологийн хүрэлцээтэй байдал нэмэгдсэн ч мэдээллийн ил тод байдлыг сайжруулах

чиглэлээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, түүнд зориулсан төсөв хангалтгүй байна. Байгууллагын чадамжийн үнэлгээг төрийн байгууллагын албан хаагчдаас авдаг тул энэ удаагийн асуумжаар мэдээлэл авах эрхийн тухай хуулийн шинэчлэлийн талаар хэр мэдээлэлтэй байгаа болон мэдээллийн ил тод байдалд COVID-19-ийн нөхцөл байдал хэрхэн нөлөөлснийг нэмэлтээр тодруулсан. Төрийн байгууллагын мэдээллийн ил тод байдлыг хангах хууль шинэчлэгдэн батлагдах шатандаа явж, ирэх жилээс хэрэгжиж эхлэх магадлал өндөр байгаа. Тиймээс тухайн байгууллагын мэдээллийн ил тод байдлыг хангах үүрэгтэй албан хаагчдаас шинэ хуулийн төслийн талаар мэдээлэлтэй эсэхийг тодруулахад үнэлгээнд оролцсон албан хаагчдын 45.7% нь ямар нэг байдлаар сонссон, мэдээлэлтэй байгаа гэжээ. Гэвч яг нарийвчлан танилцсан албан хаагч маш цөөн байна. Мөн COVID-19-ийн үеийн нөхцөл байдал мэдээллээ ил тод, нээлттэй болгоход ихэнхдээ эергээр нөлөөлсөн гэж үзсэн байна.

Цахим нээлттэй байдал

Цахим нээлттэй байдлын бүрэлдэхүүн хэсгийг төрийн байгууллагын албан ёсны цахим хуудаст байршуулсан нээлттэй мэдээлэлд үнэлгээ өгөх замаар тооцдог. Төрийн захиргааны түвшний нийт 90 байгууллагыг хамруулж, албан ёсны цахим хуудаст хандалт хийснээс 88 байгууллагын индексийг тооцон гаргасан. Энд Чингэлтэй дүүргийн ЗДТГ болон Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газрын цахим хуудаснууд засвартай байсан тул үнэлгээнд хамрагдаагүй.

Төрийн байгууллагын цахим хуудсаараа нийтэлж буй мэдээллийн хэрэгцээ шаардлага, агуулга болон хэрэглэгчдэд хүртээмжтэй байдлыг Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль болон бусад холбогдох дүрэм журамтай нийцүүлж үнэлсэн. Түүнчлэн технологийн нийцтэй ба үр ашигтай байдлыг харгалзан үзэв.

Мөн Батлан хамгаалах яам, Тагнуулын ерөнхий газар, Хил хамгаалах газар, Зэвсэгт хүчний жанжин штаб зэрэг тусгай үүргийн, зарим мэдээллүүд нь нууцлалтай байх байгууллагуудын хүний нөөцийн мэдээлэл зэргийг үнэлгээнд хасаж индексийг тооцсон.

ЗУРАГ 4

Хамрагдсан төрийн байгууллагын төрлүүд



Үнэлгээний мэдээлэл цуглуулалт буюу цахим хуудаст хандсан хугацаа нь 2021 оны 11 сараас 12-р сард хийгдсэн. Цахим нээлттэй байдлын үнэлгээнд хамрагдаагүй 2 байгууллагыг эс тооцвол төрийн байгууллагын 88 цахим хуудас хэвийн ажиллаж байсан бөгөөд ямар ч хөтөч болон гар утаснаас хайхад шууд илэрч байв. Ингэхдээ Internet explorer, Firefox, Chrome, Opera гэсэн 4 төрлийн хөтөч ашигласан. Цахим нээлттэй байдлын бүрэлдэхүүн хэсэг нь 3 дэд бүлэг 8 индикатораас бүрдэх бөгөөд 0.549 оноо авч “сул” түвшинд үнэлэгджээ. Энэхүү үзүүлэлт нь 2019 оны индексээс (0.519) 0.031 оноогоор өссөн үзүүлэлт юм. Нийт 8 индикатороос зөвхөн 2 индикатор хангалттай түвшинд үнэлэгдсэн бол үлдсэн индикаторууд сул ба хангалтгүй түвшинд үнэлэгджээ. Ихэнх цахим хуудаснууд мэдээллийн төрөл, ангилал бүрээр тусдаа цэстэй байхаас гадна төрийн бусад байгууллагууд уруу нэвтрэн орох боломжтой байсан ба тэр дундаа “Шилэн данс”, “Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем” -д байгууллагуудын 80% нь цахим хуудсаа холбосон байна. Үүнтэй холбоотойгоор төсөв, санхүүгийн ил тод байдал 2019 оноос хамгийн их өсөлттэй үзүүлэлт болж хангалттай түвшинд үнэлэгдсэн.

Технологийн үзүүлэлт “сул” (0.553) түвшинд үнэлэгдсэн. Энэ дэд бүлгийн 2 үзүүлэлт болох технологийн нийцтэй байдал болон технологийн үр нөлөөтэй байдлын үзүүлэлтүүд нь цахим нээлттэй байдлын бүрэлдэхүүн хэсгийн хамгийн сайн, хамгийн муу үзүүлэлт болж байна. Тодруулбал, технологийн нийцтэй байдлын үзүүлэлт хамгийн өндөр үзүүлэлттэй (0.741) буюу хангалттай түвшинд, “технологийн үр нөлөөтэй байдал”-ын үзүүлэлт хамгийн бага (0.366) хангалтгүй түвшинд үнэлэгдсэн. Төрийн байгууллагын цахим хуудаснууд ямар ч веб хөтөч болон хэрэгслийн хувьд нийцэн ажилладаг, хурд нь боломжийн түвшинд байгаа нь технологийн нийцтэй байдлын үзүүлэлт сайн гарахад нөлөөлсөн. Нийт 88 байгууллагын цахим хуудасны дундаж хурд 100 хувийн гүйцэтгэлтэй байхаас 78 хувийн гүйцэтгэлтэй байсан. Харин технологийн үр нөлөөтэй байдлыг хэмжсэн цахим хуудаснаас мэдээллийг хайж олох, гадаад хэлний сонголт, мэдээллийг гадаад хэл дээр нийтлэх асуудал хангалтгүй байна. Нийт үнэлгээнд хамрагдсан байгууллагын 22.7%-д нь л цахим хуудаснаас хайж буй зүйлийг хялбар олуулах зорилго бүхий сайтын бүтэц хэсэгтэй байна. Харин ердөө 6% нь гадаад хэл дээр мэдээлэл нийтэлж байна.

ХҮСНЭГТ 3

Цахим нээлттэй мэдээллийн индекс

#	Үзүүлэлтүүд	2019	2021	Үр дүн
Технологи		0.598	0.553	-0.045
1	Технологийн нийцтэй байдал	0.749	0.741	-0.008
2	Технологийн үр дүнтэй байдал	0.447	0.366	-0.081
Нээлттэй мэдээллийн агуулга		0.403	0.550	0.147
3	Үйл ажиллагаа	0.715	0.598	-0.117
4	Хүний нөөцийн бодлого	0.439	0.454	0.015
5	Төсөв, санхүү	0.507	0.697	0.19
6	Худалдан авах ажиллагаа	0.320	0.409	0.089
7	Нээлттэй өгөгдөл	0.639	0.594	-0.045
Иргэдийн оролцоо ба харилцаа		0.523	0.621	0.098
8	Харилцаа ба эгэх холбоо	0.523	0.621	0.098
Цахим ил тод байдлын индекс		0.518	0.549	0.031

Эдгээр үзүүлэлтийн үр дүнгээс шалтгаалж технологийн үр нөлөөтэй байдал энэ жилийн хамгийн муу үзүүлэлт болж, 2019 оноос 0.081 оноогоор буурчээ. Энэ үзүүлэлт өмнөх жилүүдэд ч маш хангалтгүй түвшинд үнэлэгдэж байгаа нь төрийн байгууллагууд мэдээллийг хайх үйлдлийг хялбаршуулах, мэдээллүүдээ гадаад хэл дээр байршуулахгүй ч үндсэн цэсүүдийг гадаад хэлний сонголттой болгох ажлуудыг хийж хэрэгжүүлэх шаардлагатайг харуулж байна.

Нээлттэй мэдээллийн агуулга “сул” (0.550) түвшинд үнэлэгдсэн. Төрийн байгууллагуудын нийтлэх ёстой мэдээллийн агуулгын хувьд төсөв санхүүгийн мэдээлэл хамгийн сайн буюу “хангалттай” түвшинд байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулиар зохицуулагдаж, хяналт тавьж ажилладагтай холбоотойгоор гүйцэтгэл сайн байна. Харин нээлттэй өгөгдөл буюу тухайн байгууллага цахим хуудас дээрээ байршуулсан ашиглаж болохуйц тоо баримт, мэдээ, мэдээлэл байгаа эсэх, түүнийг татаж авах боломжууд болон үйл ажиллагаатай холбоотой мэдээллүүд ‘сул’ түвшинд байна. Байгууллагуудын хувьд тендерийн урилга, тендерийн баримт бичиг, тендерт оролцогчдод тавих шалгуурыг хангалттай хэмжээнд оруулж байгаа хэдий ч тендерийн үр дүн, хэрэгжиж дууссан худалдан авах ажиллагааны тайланг оруулах байдал бүх байгууллагын хувьд “хангалтгүй” байна.

Иргэдтэй харилцах боломжийн тухайд цахим хуудсаараа иргэдийн санал гомдлыг хүлээн авах, хариу өгч шийдвэрлэх явдал 2019 онтой харьцуулахад өссөн боловч “сул” (0.621) түвшинд байсаар байна. Хэдийгээр ямар нэг шууд харилцах боломжтой хэрэгсэл байгууллагуудад байгаа хэдий ч шуурхай хариу өгөх байдал ихэнх байгууллагуудын хувьд дутмаг байна. Иргэдтэй харилцах цэсийн үйл ажиллагаа нэмэгдсэн нь COVID-19 цар тахлын нөлөө байхыг үгүйсгэхгүй. Гэвч цаашид сайжруулах зайлшгүй шаардлагатай байна. Иргэдтэй шууд харилцах болон санал, хүсэлт, гомдол гаргах хэсгүүд эсвэл шууд харилцах боломжтой нийгмийн сүлжээний холбоосыг байршуулах нь мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлэх нэг гол хүчин зүйл юм. Эдгээр цэсүүдийг идэвхтэй ажиллуулж, санал хүсэлт болон иргэдийн хандалтад дүн шинжилгээ хийж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээнд энэ дүн шинжилгээний мэдээллийг ашиглаж эхэлбэл мэдээллийн урсгал, ил тод байдал хангагдах хамгийн чухал суурь болно.

Төрийн байгууллагын цахим хуудасны ил тод байдлын өөрчлөлт

IRIM судалгааны хүрээлэн нь 10 дахь жилдээ энэхүү судалгааг гүйцэтгэж байна. Тиймээс өнгөрсөн хугацааны төрийн байгууллагын цахим ил тод байдалд гарсан өөрчлөлтийг нэгтгэн харуулж байна.

Анх 2010 онд судалгаанд хамрагдсан 81 төрийн байгууллагын цахим хуудасны ил тод байдал ердөө 17.7 хувьтай байв. Тухайн үед төрийн байгууллагын “Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт”-ийг батлаад дөнгөж нэг жилийн хугацаа өнгөрч байсан. Үүний дараа 2011 онд нэмэгдэж 28.7 хувьд хүрсэн ч хангалтгүй хэвээр байв. Үнэлгээ хийж эхэлснээс хойш 5 жилийн дараа буюу 2015 онд төрийн байгууллагын цахим ил тод байдлын индекс өсөж “хангалтгүй”

түвшнээс “сул” түвшинд үнэлэгдэж эхэлсэн. Энэхүү өсөлтийн шалтгаан нь 2014 оны 7 сард Шилэн дансны тухай хууль хэрэгжиж төрийн байгууллагууд төсөв санхүүгийн ил тод байдлаа цахим хуудсаараа дамжуулан мэдээлэлдэг болсонтой холбоотой. Нээлттэй мэдээллийн агуулга дотроос төсөв, санхүүгийн ил тод байдал нь сүүлийн 5 жилийн хугацаанд тасралтгүй өсөж байгаа үзүүлэлт юм.

Гэвч сүүлийн 7 жилийн хугацаанд төрийн байгууллагын цахим хуудасны ил тод байдал төдийлөн өссөнгүй. Үүнд төрийн мэдээллийн ил тод байдлыг хянах, хариуцлага тооцох механизм сул байгаатай холбоотой.

Үнэлгээг анх хийж эхэлснээс хойш дараах 6 төрлийн төрийн байгууллагын цахим хуудсыг тогтмол үнэлж ирсэн ба өнгөрсөн 10 жилийн турш хийж ирсэн цахим ил тод байдлын үр дүнг байгууллагын төрлөөр Хүснэгт 4-т харууллаа.

ЗУРАГ 5


Төрийн байгууллагын цахим хуудасны ил тод байдлын өөрчлөлт, оноор хувиар



Сайн | >80 Хангалттай | 65-79 Сул | 50-64 Хангалтгүй | 35-49 Муу | <35

ЗУРАГ 6

Төрийн байгууллагын цахим хуудасны ил тод байдлын өөрчлөлт



Эх сурвалж: Төрийн байгууллагын цахим хуудасны ил байдлын мониторинг, IRIM судалгааны хүрээлэн

Дүүргүүдийн ЗДТГ-ууд 2010 оны хувьд бусад байгууллагуудтай харьцуулахад цахим ил тод байдлын индексээр хамгийн доогуур эрэмбэлэгдэж байсан хэдий ч 2016 оныг хүртэл тасралтгүй өсөж 2016 онд нэгт эрэмбэлэгдэж байв. Үүнд ихэнх дүүргийн ЗДТГ газрууд дотоод хайлтын системтэй болсон, байгууллагын бүтэц, хүний нөөцийн мэдээлэл сайжирсан, байгууллагаас гаргасан хууль дүрэм журмыг тогтмол шинэчилдэг болсон нь нөлөөлсөн. Гэвч сүүлийн жилүүдэд цахим ил тод байдлын индекс төдийлөн сайжрахгүй байгаа нь Хүснэгт 4-с харагдаж байна. Энэ нь дүүргүүдийн веб сайтаас мэдээллийг хялбар олуулах зорилго бүхий сайтын бүтэц хэсэг байхгүй, гадаад хэл дээр мэдээлэл нийтэлдэггүй, худалдан авах үйл ажиллагааны ил тод байдал дутмаг байгаатай холбоотой.

Яамдын хувьд сүүлийн 10 жилийн хугацаанд 2016, 2019 онуудыг эс тооцвол өсөлттэй байгаа бөгөөд ялангуяа 2021 онд өнгөрсөн жилээс мэдэгдэхүйц өссөн. Үүнд бүх яамдад төсвийн ил тод байдлыг хангах тодорхой тусдаа хэсэгтэй бөгөөд тухайн цэс нь шилэн дансанд холбогдсон, төсөв санхүүтэй холбоотой мэдээллийг жил, сар, улирал бүрээр оруулдаг нь нөлөөлсөн.

Парламентын харьяа байгууллагуудын хувьд мөн адил сүүлийн хоёр жил өсөлттэй байгаа боловч хэлтсийн дарга, холбогдох албан тушаалтнуудын мэдээлэл байршуулах, цахим хуудас дээр шууд харилцах, түүнд шуурхай

хариу өгөх процесст төдийлөн ахиц гарахгүй байна.

Аймгуудын ЗДТГ-ын цахим хуудсууд 2017 оныг хүртэл үзүүлэлт сайжирч байсан боловч, үүнээс хойш төдийлөн ахиц гарсангүй. Хэрэгжүүлэгч болон тохируулагч агентлагын үр дүнгүүд 2017 он хүртэл ойролцоо үзүүлэлттэй үнэлэгдэж байсан бол түүнээс хойш энэ үнэлгээ өөрчлөгдөж байна.

Байгууллагуудын үр дүн

Энэ хэсэгт цахим ил тод байдлын үр дүнг байгууллагын түвшинд авч үзнэ. Нийт байгууллагын үр дүнг харахад ихэнх байгууллагын ил тод байдлын индекс 2019 онтой харьцуулахад буурсан байна. Нэгдсэн оноогоор 2019 онд Дүүргүүдийн ЗДТГ 0.630 оноогоор тэргүүлж байсан бол 2021 онд яамд байгууллагын ангиллын төрөлд 0.648 оноогоор тэргүүллээ. Энэ нь яамдын хувьд цахим нээлттэй байдал болон байгууллагын чадамж 2019 онтой харьцуулахад мэдэгдэхүйц өссөнтэй холбоотой. Тэр дундаа цахим нээлттэй байдлын хувьд 2020 онд Зам тээвэр хөгжлийн яам “хангалттай” түвшинд үнэлэгдсэн ганц яам болж байсан бол энэ жилийн хувьд 6 яамд ‘хангалттай’ түвшинд үнэлэгдсэн нь онцлох үр дүн юм. 2019 оны хувьд Тохируулагч агентлагууд байгууллагын ангилал төрөлд хамгийн сүүлд орж байсан бол энэ онд 0.054 оноогоор өсөж хамгийн их

ХҮСНЭГТ 4

Индексийн үр дүн, байгууллагын ангиллаар

#	Байгууллагын төрөл	Эрх зүйн орчин	Байгууллагын чадамж	Цахим нээлттэй байдал	2021 оны ерөнхий индекс	2019 оны ерөнхий индекс	Зөрүү
1	Дүүргүүдийн ЗДТГ	0.631	0.566	0.799	0.612	0.630	-0.018
2	Монгол Улсын яамд		0.763	0.550	0.648	0.627	0.021
3	Парламентын харьяа байгууллагууд		0.566	0.594	0.597	0.626	-0.029
4	Аймгуудын ЗДТГ		0.572	0.550	0.584	0.618	-0.034
5	Хэрэгжүүлэгч агентлагууд		0.663	0.492	0.595	0.599	-0.004
6	Тохируулагч агентлагууд		0.724	0.544	0.633	0.579	0.054
Ерөнхий дундаж		0.631	0.631	0.549	0.602	0.612	-0.01

Бүрэлдэхүүн хэсгээр авч үзвэл дүүргийн ЗДТГ-ын хувьд байгууллагын чадамж хамгийн багаар үнэлэгдсэн бол тохируулагч агентлагууд цахим нээлттэй байдал хамгийн бага байна. Үүнийг байгууллагын төрөл тус бүрээр нарийвчлан дараагийн хэсгүүдэд танилцууллаа.

Яамдын цахим ил тод байдал

Нийт 14 яамны цахим ил тод байдлыг үнэлсэн бөгөөд яамны ангилал дотроо 2019 онд Хүнс, хөдөө, аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн яам 0.753 оноогоор тэргүүлж байсан бол 2021 оны хувьд Сангийн яам 0.724 оноогоор тэргүүлж байна. Гэсэн хэдий ч энэ оноо 2019 оны үр дүнгээс бага зэрэг буурсан үзүүлттэй байна. 2019 онд 3 яамны цахим ил тод байдал “хангалттай” түвшинд үнэлэгдэж байсан бол энэ жил 5 байгууллага “хангалттай” түвшинд

үнэлэгдэж 2 байгууллагаар нэмэгджээ. Үүний үр дүнд Яамдын цахим ил тод байдлын индекс улсын дунджаас өндөр гарсан. Мөн хангалтгүй түвшин үнэлэгдсэн яам байгаагүй. Харин 8 яамны цахим ил тод байдал “сул” түвшинд үнэлэгдсэн. Хэдийгээр нэгдүгээрт эрэмбэлэгдээгүй ч яамны ангилал дотроо Байгаль орчин аялал жуулчлалын яам 2019 онтой харьцуулахад хамгийн их өсөлт үзүүлсэн байгууллага болсон.

2020 оноос хойш дэлхий нийтэд цар тахал гарсны улмаас Монгол Улс эрүүл мэндийн салбарт авах арга хэмжээгээ нэмэгдүүлж, хил хаасантай холбоотой Гадаад харилцааны яам болон Эрүүл мэндийн яамдаас мэдээлэл өгөх, иргэдийн мэдээлэл авах хэрэгцээ нэмэгдсэн. Гэвч эдгээр яамдын цахим ил тод байдлын үзүүлэлт огтхон ч сайжраагүй байгаа нь шүүмжлэлтэй үзүүлэлт юм.

ХҮСНЭГТ 5

Цахим нээлттэй байдлын үр дүн, яамаар

Эрэмбэ	Яамд	2021 он	2019 он	Оноо
1	Сангийн яам	0.724	0.732	-0.008
2	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	0.713	0.753	-0.04
3	Барилга, хот байгуулалтын яам	0.684	0.517	-0.167
4	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам	0.658	0.624	0.034
5	Зам, тээврийн хөгжлийн яам	0.651	0.665	0.014
6	Байгаль орчин, аялал жуулчлалын яам	0.638	0.556	0.082
7	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	0.635	0.556	0.079
8	Батлан хамгаалах яам	0.625	NA	-
9	Эрүүл мэндийн яам	0.613	0.667	-0.054
10	Хууль зүй, дотоод хэргийн яам	0.606	0.568	0.038
11	*Боловсрол, шинжлэх ухааны яам	0.600	0.639	-0.039
12	*Соёлын яам	0.585	NA	-
13	Эрчим хүчний яам	0.575	0.655	-0.077
14	*Гадаад харилцааны яам	0.538	0.597	0.059
Яамдын индекс		0.648	0.627	0.576
Монгол Улсын дундаж индекс		0.602	0.612	

Яамдын хувьд цахим ил тод байдалд дараах нийтлэг давуу болон сул тал ажиглагдаж байв.

Давуу тал	Сул тал
Бүх яамны цахим хуудас нь технологийн хувьд нийцэл сайтай буюу ямар ч веб хөтөч болон хэрэгслээс хандах бүрэн боломжтой	Гадаад хэл дээрх мэдээллүүд хангалтгүй. Хэдийгээр хэлний сонголттой боловч хэсэгчлэн орчуулагдсан байдаг.
Бүх яамны цахим хуудсыг хайж олоход хялбар. Мөн мэдээллийг хурдан хайж олох боломжтой хайлтын хэрэгсэлтэй байна.	Хүний нөөцийн талаарх мэдээллүүд сайн боловч холбогдох мэргэжилтэн албан тушаалтнуудын мэдээлэл солигддоггүй.
Байгууллагуудын ажилтнуудад цахим платформуудыг ашиглах боломж хангалттай нээлттэй байдаг	Төсөв санхүүгийн мэдээлэл сайн боловч, худалдан авах ажиллагааны талаар холбогдох мэдээлэл хангалтгүй.
Байгууллагаас гаргасан шийдвэртэй холбоотой мэдээллийг ил тод нийтэлдэг. Бүх холбогдох тогтоол, журмыг цахим хуудаснаас харж болно.	Цахим хуудсанд иргэдтэй шууд харилцах, тэдний санал, гомдлыг хүлээн авах хэсэг байхгүй. Сошиал хаягтай холбогдох цэстэй боловч дамжин орох процесс нь алдаатай.
Мэдээ, мэдээллийг байнга шинэчилдэг. Холбогдох мэдээллийг татаж авах боломжтой байдаг.	Веб сайтад хандсан хүний тоо байхгүй.
Төсөв санхүүтэй холбоотой мэдээллийг жил, сар, улирал бүрээр оруулдаг. Бүх яамдад төсвийн ил тод байдлыг хангах тодорхой тусдаа хэсэгтэй бөгөөд шилэн дансанд холбогдсон байдаг.	Холбоо барих мэдээллийг зөвхөн хэсэгчилэн оруулсан буюу албан ёсны хаягийг газрын зурагт тэмдэглэсэн мэдээлэл хангалтгүй.

Хэрэгжүүлэгч агентлагуудын цахим ил тод байдал

Нийт үйл ажиллагаа явуулж буй 26 хэрэгжүүлэгч агентлагуудын цахим ил тод байдлыг үнэлсэн бөгөөд хэрэгжүүлэгч агентлаг дотроо 2019 онд Ашигт малтмал газрын тосны газар 0.718 оноогоор тэргүүлж байсан бол 2019 оны хувьд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар 0.703 оноогоор тэргүүлсэн байна. 2019 онд 5 хэрэгжүүлэгч агентлагийн цахим ил тод байдал “хангалттай” түвшинд үнэлэгдэж байсан бол энэ жилийн хувьд 6

болж нэг байгууллагаар нэмэгджээ. Гэвч 2019 оны цахим ил тод байдлын индексэд 9 байгууллага хамрагдаагүй гэдгийг тэмдэглэх нь зүйтэй. 18 хэрэгжүүлэгч агентлагийн цахим ил тод байдал “сул” түвшинд байгаа бол үлдсэн 2 агентлаг “хангалтгүй” түвшинд үнэлэгдлээ. Хэрэгжүүлэгч агентлагуудаас Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар 2019 оноос сайжирч ‘сул’ түвшинээс ‘хангалттай’ түвшинд ил тод байдал нэмэгджээ. Эсрэгээр Мал эмнэлгийн ерөнхий газар “сул” түвшнээс “хангалтгүй” түвшинд ил тод байдал нь буурсан байна.

ХҮСНЭГТ 6

Цахим нээлттэй байдлын үр дүн, хэрэгжүүлэгч агентлагаар

Эрэмбэ	Хэрэгжүүлэгч агентлаг	2021 он	2019 он	Оноо
1	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар	0.703	0.694	0.009
2	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар	0.698	0.465	0.233
3	Ус сувгийн удирдах газар	0.686	NA	-
4	Татварын ерөнхий газар	0.654	0.673	-0.019
5	Архивын ерөнхий газар	0.645	0.504	0.141
6	Иргэний нисэхийн ерөнхий газар	0.639	0.629	0.01
7	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар	0.635	0.636	-0.001
8	Нийслэлийн шинжлэх ухаан, үйлдвэрлэл инновацийн газар	0.620	0.633	-0.013
9	Төрийн худалдан авах ажиллагааны газар	0.616	NA	-
9	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар	0.616	NA	-
10	*Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар	0.603	NA	-
11	Биеийн тамир спортын газар	0.598	0.526	0.072
12	*Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар	0.596	0.554	0.042
13	*Оюуны өмчийн газар	0.594	NA	-
14	*Нийгмийн даатгалын ерөнхий газар	0.569	NA	-
15	Ашигт малтмал, газрын тосны газар	0.558	0.718	0.16
16	Үндэсний геологийн алба	0.549	NA	-
16	*Жижиг, дунд үйлдвэрийн газар	0.549	NA	-
17	Гаалийн ерөнхий газар	0.537	0.715	-0.178
18	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар	0.535	0.614	0.395
19	*Соёл урлагийн газар	0.524	0.515	0.009
20	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар	0.509	0.597	-0.088
21	Гадаадын иргэн, харьяатын газар	0.507	0.652	-0.145
22	Цаг уур, орчны шинжилгээний газар	0.507	0.528	0.227
23	Мал эмнэлгийн ерөнхий газар	0.490	0.528	-0.038
24	Улсын бүртгэлийн ерөнхий газар	0.450	NA	-
Хэрэгжүүлэгч агентлагуудын индекс		0.595	0.599	
Монгол Улсын индекс		0.602	0.612	

Хэрэгжүүлэгч агентлагуудын цахим ил тод байдлын хувьд дараах нийтлэг давуу болон сул тал ажиглагдаж байв.

Давуу тал	Сул тал
Төсөв санхүүтэй холбоотой мэдээллүүдийг байршуулах байдал сайн.	Ихэнх байгууллагын цахим хуудсанд байгууллагын хэлтсийн дарга нарын нэр, утасны жагсаалт хангалттай бус, байршуулаагүй. Үүнийг зөвхөн бүтцийн зураглалаар харуулдаг.
Үзүүлж буй үйлчилгээний талаарх мэдээлэл хангалттай.	Гадаад хэл дээрх мэдээлэл хангалтгүй. Хэлний сонголттой боловч ажилладаггүй.
Статистик мэдээлэл болон судалгааг байршуулах байдал хангалттай.	Дотоод хайлтын систем хангалтгүй. Ихэнх байгууллагад байхгүй. Дотоод хайлтын системтэй ч ажилладаггүй.
Ихэнх агентлагууд ажлын байрны зарыг тогтмол мэдээлэлдэг.	Цахим хуудасны бүтэц хэсэг байхгүй учир мэдээлэл олоход хүндрэлтэй.
Нийгмийн сүлжээ рүү холбогдох холбоос бүх агентлагуудын цахим хуудсанд багтсан.	Цахим хуудас дээрх иргэдтэй харилцах, санал гомдол авах хэсэг зарим байгууллагын хувьд хангалтгүй.
Цаг үеийн мэдээллийг тогтмол сайн мэдээлэлдэг.	Худалдан авах үйл ажиллагаа, тендэрийн үр дүн, сонгон шалгаруулах журмын мэдээлэл хангалтгүй

Тохируулагч агентлагуудын цахим ил тод байдал

Нийт үйл ажиллагаа явуулж буй 10 тохируулагч агентлагийн цахим ил тод байдлыг үнэлэхэд 2019 онд Харилцаа холбоо, мэдээлэл технологийн газар 0.674 оноогоор тэргүүлж байсан бол 2021 онд мөн тус газар 0.696 оноогоор тэргүүлсэн байна. 2019 онд Харилцаа холбоо мэдээлэл технологийн газар “хангалттай” түвшинд үнэлэгдсэн ганц тохируулагч агентлаг болж байсан бол энэ

жилийн хувьд Цагдаагийн ерөнхий газар, Онцгой байдлын ерөнхий газар мөн адил “хангалттай” түвшинд үнэлэгдсэн байна. Үлдсэн 7 агентлаг нь “хангалтгүй” түвшинд үнэлэгдсэн бөгөөд “сул” түвшинд үнэлэгдсэн тохируулагч агентлаг байсангүй. Үүний үр дүнд тохируулагч агентлагын дундаж оноо улсын дунджаас өндөр байна. 2019 оны индекст оролцсон 8 агентлагаас Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Хил хамгаалах ерөнхий газар, Төрийн тусгай хамгаалалттай газруудын цахим ил тод байдал буурсан үзүүлэлттэй байна.

ХҮСНЭГТ 7

Цахим нээлттэй байдлын үр дүн, тохируулагч агентлагаар

Эрэмбэ	Тохируулагч агентлаг	2021 он	2019 он	Оноо
1	Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар	0.696	0.674	0.022
2	Цагдаагийн ерөнхий газар	0.692	0.591	0.101
3	Нийслэлийн онцгой байдлын газар	0.688	0.626	0.062
4	Үндэсний хөгжлийн газар	0.608	0.580	0.028
5	*Мэргэжлийн хяналтын ерөнхий газар	0.597	0.602	-0.005
6	*Стандарт, хэмжил зүйн газар	0.592	0.569	0.023
7	*Төрийн тусгай хамгаалалтын газар	0.545	0.569	-0.024
8	*Зэвсэгт хүчний жанжин штаб	0.535	NA	
9	*Хил хамгаалах ерөнхий газар	0.521	0.573	-0.052
10	*Тагнуулын ерөнхий газар	0.509	NA	-
Тохируулагч агентлагийн индекс		0.633	0.579	
Монгол Улсын индекс		0.602	0.612	

Тохируулагч агентлагуудын цахим ил тод байдлын хувьд дараах нийтлэг давуу болон сул тал ажиглагдаж байв.

Давуу тал	Сул тал
Бусад төрийн байгууллагуудын цахим хуудас руу орох холбоосыг хоёроос бусад бүх агентлагууд өөрийн цахим хуудсандаа байршуулсан	Цахим хуудасны бүтцийн хэсэг байхгүй, түүнчлэн гадаад хэл дээрх мэдээллүүд хангалтгүй
Цахим хуудсанд ямар ч хөтчөөс хандах боломжтой	Дотоод хайлтын систем ихэнх агентлагт байхгүй.
Порталын агуулга хангалттай	Холбогдох хэлтсийн дарга, албан тушаалтны мэдээлэл ихэнх агентлаг байршуулаагүй.
Ихэнх агентлагууд тусгай эсвэл нэгдсэн сервертэй	Цахим хуудас дээрээ статистик мэдээлэл болон үйлчилгээний талаарх бүртгэлийн тоо баримт оруулдаггүй.

Аймгийн ЗДТГ-уудын цахим ил тод байдал

Нийт 21 аймгийн ЗДТГ-ын цахим ил тод байдлыг үнэлэхэд энэ ангилал дотроо 2019 онд 0.774 оноогоор Дундговь аймгийн ЗДТГ тэргүүлж байсан бол 2021 онд 0.766 оноогоор Өвөрхангай аймаг тэргүүлжээ. 2019 онд 6 аймгийн цахим ил тод байдал

“хангалттай” түвшинд үнэлэгдэж байсан бол энэ жилийн хувьд мөн адил 6 байгууллага “хангалттай” түвшинд үнэлэгдлээ. 2019 онд хамрагдаж байсан 19 аймгаас 11 аймгийн индекс энэ онд буурсан үзүүлэлттэй байна. Үүнтэй холбоотойгоор 2021 аймгийн ерөнхий дундаж оноо 2019 оноос 0.034 оноогоор буурсан байна.

ХҮСНЭГТ 8

Цахим нээлттэй байдлын үр дүн, аймгаар

Эрэмбэ	Аймгийн ЗДТГ	2021 он	2019 он	Оноо
1	Өвөрхангай аймаг	0.766	0.769	-0.003
2	Өмнөговь аймаг	0.720	0.711	0.009
3	Булган аймаг	0.680	0.637	0.043
4	Дархан-Уул аймаг	0.673	0.733	-0.06
5	Орхон аймаг	0.661	NA	-
6	Хөвсгөл аймаг	0.660	0.582	0.078
7	Говьсүмбэр аймаг	0.618	0.558	0.06
8	Ховд аймаг	0.603	0.465	0.138
9	Хэнтий аймаг	0.602	0.658	-0.056
10	Увс аймаг	0.591	0.664	-0.073
11	Баян-Өлгий аймаг	0.579	NA	-
12	Говь-Алтай аймаг	0.572	0.695	-0.123
13	Завхан аймаг	0.563	0.540	0.023
14	Баянхонгор аймаг	0.531	0.534	-0.003
15	Дорнод аймаг	0.529	0.413	0.116
16	Архангай аймаг	0.525	0.636	-0.111
17	Дорноговь аймаг	0.501	0.670	-0.169
17	Дундговь аймаг	0.501	0.774	-0.273
18	Сэлэнгэ аймаг	0.489	0.634	-0.145
19	Төв аймаг	0.489	0.482	0.007
20	Сүхбаатар аймаг	0.425	0.583	-0.158
Аймгийн ЗДТГ-ын индекс		0.584	0.618	
Монгол Улсын индекс		0.602	0.612	

Аймгийн ЗДТГ-ын цахим ил тод байдлын хувьд дараах нийтлэг давуу болон сул тал ажиглагдаж байв.

Давуу тал	Сул тал
Ямар ч төрлийн хөтөч, хайлтын системээс төвөггүй нэвтрэх боломжтой.	Гадаад хэлний сонголт байхгүй. Гадаад хэл дээрх мэдээлэл, сайтын цэс байхгүй.
Байгууллагын бүтэц болон холбогдох албан тушаалтнуудын мэдээллийг байршуулах байдал сайн.	Аливаа хэрэгцээт мэдээлэл, нээлттэй өгөгдлийг татах боломжгүй.
Төсөв, санхүү хүний нөөцийн талаарх мэдээллүүдийг нээлттэй ил тод байршуулах байдал бусад байгууллагатай харьцуулахад өндөр.	Шууд харилцах боломж бүхий хэсэг байхгүй.
Орон нутгаас гаргаж буй шийдвэрүүдийг тухай бүрд нийтэлдэг.	Ихэнх аймгийн цахим хуудаст хандсан хүний тоог харах боломжгүй байна.
Бусад төрийн байгууллагатай холбогдох холбоос хоёроос бусад аймагт байршсан.	Худалдан авах үйл ажиллагааны ил тод байдлыг харах цэс ихэнх аймагт байхгүй.

Дүүргийн ЗДТГ-уудын цахим ил тод байдал

Нийт 8 дүүргийн ЗДТГ-ын цахим ил тод байдлыг үнэлсэн бөгөөд дүүргийн ЗДТГ-ын ангилал дотроо 2019 онд Чингэлтэй дүүрэг 0.684 оноогоор тэргүүлж байсан бол 2021 онд 0.747 оноогоор Хан-Уул дүүрэг тэргүүллээ. Энэ удаагийн үнэлгээнд Чингэлтэй дүүргийн ЗДТГ-ын цахим хуудас засвартай байсан тул хамрагдаагүй. Дүүргүүдийн ЗДТГ-ын цахим ил тод байдлыг 2019 онтой харьцуулахад

бага зэрэг буурсан үзүүлэлт харагдаж байна. Хэдийгээр “хангалттай” түвшинд үнэлэгдсэн дүүргийн тоо 2-оос 4 болж өссөн боловч “хангалтгүй” түвшинд үнэлэгдсэн дүүрэг энэ дундаж индексийг буурахад нөлөөлжээ. Баянзүрх дүүргийн ЗДТГ, Багануур дүүргийн ЗДТГ 2019 онд “сул” түвшинд үнэлэгдэж байсан бол энэ онд “хангалттай” түвшинд ил тод байдал нэмэгдсэн бол эсрэгээр Багахангай болон Сүхбаатар дүүргийн ЗДТГ “сул” түвшнээс “хангалтгүй” түвшин рүү буурсан үзүүлэлттэй байна.

ХҮСНЭГТ 9

Цахим нээлттэй байдлын үр дүн, дүүргээр

Эрэмбэ	Дүүргийн ЗДТГ	2021 он	2019 он	Оноо
1	Хан-Уул дүүргийн ЗДТГ	0.747	NA	-
2	Баянзүрх дүүргийн ЗДТГ	0.685	0.612	0.073
3	Багануур дүүргийн ЗДТГ	0.670	0.580	0.09
4	Налайх дүүргийн ЗДТГ	0.654	0.678	-0.024
5	Сонгинохайрхан дүүргийн ЗДТГ	0.639	-	-
6	Баянгол дүүргийн ЗДТГ	0.625	0.620	0.005
7	Багахангай дүүргийн ЗДТГ	0.456	0.619	-0.163
8	Сүхбаатар дүүргийн ЗДТГ	0.425	0.616	-0.191
Дүүргийн ЗДТГ-ын индекс		0.612	0.630	
Монгол Улсын индекс		0.602	0.612	

Нийслэлийн дүүргүүдийн ЗДТГ-ын цахим ил тод байдлын хувьд дараах нийтлэг давуу болон сул тал ажиглагдаж байв.

Давуу тал	Сул тал
Дотоод хайлтын системийг нэгээс бусад цахим хуудаст шийдсэн.	Цахим хуудаст хайж буй зүйлийг хялбар олуулах зорилго бүхий сайтын бүтэц хэсэг байхгүй
Байгууллагын бүтэц, хүний нөөцийн талаарх мэдээлэл сайн.	Гадаад хэл дээр мэдээлэл оруулдаггүй.
Төсөв санхүүгийн үзүүлэлтүүдийг хангах байдал сайн.	Худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах байдал сул.
Бүх дүүргүүд байгууллагаас гаргасан шийдвэрийн тухай тогтмол мэдээлэлдэг.	Нээлттэй өргөдөл, материалыг татаж авах боломж огт хангагдаагүй.
Бусад мэдээ, мэдээллүүдийг тогтмол шинэчилж, цаг тухай бүрт нь нийтэлдэг.	Ямар нэг байдлаар санал, хүсэлт, гомдол гаргах механизм ихэнх дүүргийн цахим хуудаст бүрдээгүй.
Бусад холбогдох нийгмийн сүлжээ рүү холбогдох байдал сайн.	Цахим хуудсаар зочилсон хандалтыг зарим дүүргүүд нээлттэй харуулдаггүй.

Парламентын харьяа байгууллагуудын цахим ил тод байдал

Парламентийн байгууллагуудын ерөнхий дундаж индекс 2019 онтой харьцуулахад мэдэгдэхүйц өөрчлөлт гараагүй, цахим ил тод байдал “сул” түвшинд байна. Нийт 9 парламентын харьяа байгууллагын цахим ил

тод байдлыг үнэлэхэд 2019 онд Монгол банк 0.719 оноогоор тэргүүлж байсан бол 2021 онд 0.680 оноогоор мөн тус байгууллага тэргүүлсэн байна. 2019 онд 5 байгууллага “хангалттай” түвшинд үнэлэгдэж байсан бол 2021 онд 3 болж буурчээ. Сонгуулийн ерөнхий хороо, Санхүүгийн зохицуулах хороо, Төрийн албаны зөвлөлөөс бусад 6 байгууллагын индекс 2019 оноос буурсан үзүүлэлттэй байна.

ХҮСНЭГТ 10

Цахим нээлттэй байдлын үр дүн, парламентын харьяа байгууллагаар

Эрэмбэ	Парламентын харьяа байгууллагууд	2021 он	2019 он	Оноо
1	Монгол банк	0.680	0.719	-0.039
2	Авлигатай тэмцэх газар	0.670	0.688	-0.018
3	Санхүүгийн зохицуулах хороо	0.657	0.636	0.021
4	Сонгуулын ерөнхий хороо	0.647	0.516	0.131
5	Төрийн албаны зөвлөл	0.596	0.486	0.110
6	Үндэсний статистикийн хороо	0.593	0.601	-0.008
7	*Үндэсний аудитын газар	0.585	0.601	-0.016
8	Улаанбаатар хотын захирагчын алба	0.497	0.653	-0.156
9	Хүний эрхийн үндэсний комисс	0.455	0.664	-0.185
Дүүргийн ЗДТГ-ын индекс		0.610	0.626	
Монгол Улсын индекс		0.597	0.612	

Парламентын харьяа байгууллагуудад дараах нийтлэг давуу болон сул тал ажиглагдаж байв.

Давуу тал	Сул тал
Дотоод хайлтын систем ихэнх байгууллагууд шийдсэн.	Хэлтсийн дарга, холбогдох мэдээлэл ихэнх байгууллагуудад байршуулаагүй.
Байгууллагаас гаргасан шийдвэрийн тухай болон бусад мэдээллүүдийг тогтмол шинэчилж, мэдээлэлдэг.	Цахим хуудас дээрх ил тод байдлын хэсэг хангалтгүй, зарим мэдээллүүдийг дутуу оруулсан.
Нийгмийн сүлжээ рүү холбогдох холбоосуудаа бүх байгууллага байршуулсан.	Цахим хуудас дээр шууд харилцах боломж ихэнх байгууллагад байхгүй.

Дүгнэлт, зөвлөмж

Төрийн байгууллагын цахим ил тод байдлын индекс 0.602 буюу 'сул' түвшинд үнэлэгдсэн ба сүүлийн 5 жилийн хугацаанд уг үзүүлэлтэд мэдэгдэхүйц өөрчлөлт гараагүй байна. Индексийг тооцоход авч үзсэн бүрэлдэхүүн үзүүлэлтүүдийн үр дүнг нэгтгэн авч үзвэл:

Эрх зүйн орчны индекс 0.631 оноо авч 'сул' түвшинд үнэлэгдлээ. 2019 онд Монгол Улсын цахим ил тод байдлын эрх зүйн орчин 0.657 оноо авч хангалттай түвшинд үнэлэгдэж байсан бол даруй 2 жилийн дараа гэхэд уг үзүүлэлт буурсан дүнтэй байна. Энэ хугацаанд мэдээлэл авах эрхийн хүрээнд нээлттэйгээр авах боломжтой мэдээллийн хүрээ хумигдаж, засаглалын бүх үзүүлэлтүүд болон иргэний нийгмийн бүлэг хэсгийн хэвлэл мэдээллийн эрх чөлөөнөөс бусад үзүүлэлтүүд бууралттай гарлаа. Буурсан дүнтэй гарсан үзүүлэлтүүдээс иргэний нийгмийн төлөвшил хамгийн ихээр буурсан нь иргэдийн мэдээлэл авах эрхийг хангах чиглэлд цаашид анхаарах шаардлагатай.

Байгууллагын чадамжийн индекс 0.627 буюу 'сул' түвшинд үнэлэгдлээ. Ялангуяа мэдээллийн ил тод байдлыг хангахад чиглэсэн үүрэг бүхий албан тушаалтан томилох болон мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлэх чиглэлээр ажилтныг хөгжүүлэх, хянах механизм сул хэвээр байна. Мөн мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлэх арга хэмжээг иргэдийн санал, гомдолд үндэслэн сайжруулах байдал сул. Энэ чиглэлээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, түүнд зориулсан төсөв хангалтгүй байгаа нь мэдээллийн ил тод байдал нэмэгдэхгүй байх нэг үндсэн шалтгаан болж байна.

Цахим нээлттэй мэдээллийн индекс 0.549 буюу 'сул' түвшинд үнэлэгдлээ. Төрийн байгууллагууд цахим хуудсандаа мэдээллийн ил тод байдлыг хангахад чиглэсэн тусдаа цэстэй, мэдээллийн төрөл, ангилал бүрээр мэдээллээ оруулж байгаа ч оруулсан мэдээллийн агуулга харилцан адилгүй байна. Тэр дундаа "шилэн

данс", "төрийн худалдан авах ажиллагааны цахим систем"-д байгууллагуудын 80 хувь нь цахим хуудсаа холбосон, холбоосоор дамжин шууд нэвтрэн орох боломжтой байна. Эдгээр системүүдээр дамжуулан Сангийн яам хяналт тавьдагтай холбоотойгоор төсөв, санхүүгийн ил тод байдал хамгийн их өсөлттэй байж, хангалттай түвшинд үнэлэгдсэн. Тиймээс хяналтын тодорхой механизм нь мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой байна.

Цахим нээлттэй байдлын нэг чухал үзүүлэлт болох технологийн хувьд тухайн цахим хуудаснаас хэрэглэгчид хэрэгтэй мэдээллээ хялбар хайж олох, харилцах боломжийг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Үнэлгээний үр дүнд үндэслэн цаашид төрийн байгууллагууд цахим хуудсаа сайжруулахад дараах санал зөвлөмжүүдийг хүргэж байна. Үүнд:

- Цахим ил тод байдлыг нэмэгдүүлэх чиглэлээр иргэд, судалгаа шинжилгээний байгууллагаас ирсэн санал, гомдолд байгууллага бүр жил тутам шинжилгээ хийж, цаашид хэрхэн сайжруулж болох талаар төлөвлөгөө боловсруулж, ирэх жилийн үйл ажиллагаандаа шаардлагатай төсвийн хамт тусгах. Үүнд хэрэглэгчийн хандалт болон цахим хуудасны ашиглалт, агуулгад үнэлгээ хийх, шаардлагатай хүний нөөцийг хөгжүүлэх, сургах зэрэг үйл ажиллагаануудыг төлөвлөх.
- Төрийн байгууллагын цахим хуудаст тавих шаардлага (MNS 6825:2017) стандартыг бүрэн хангаж ажиллах
- Иргэд цахим хуудсыг хялбар ашиглах боломжийг нэмэгдүүлэх. Тухайлбал, цахим хуудаст хайж буй зүйлийг хялбар олуулах зорилго бүхий сайтын бүтэц хэсэгтэй болох. Мөн сайтаас мэдээллийг хялбар олох хайлтын системийг боловсронгуй болгох. Ингэхдээ цахим хуудасны хайлтын хэсгийг google холбоостой холбохгүй байх.

Энэ нь цахим хуудаснаас мэдээлэл хайж олоход хүндрэлтэй байгаа асуудлыг шийдвэрлэнэ. Мөн цахим хуудсыг хэлний сонголттой болгож, эхний ээлжинд сайтын цэс хэсгийг бүрэн орчуулагдсан байдлыг хангах, үүний дараа оруулж буй мэдээллийн агуулгыг хэлний сонголттойгоор хүргэдэг болох зэрэг шат дараатай арга хэмжээг хэрэгжүүлж, бүх хүн мэдээллийг тэгш авах боломжийг бүрдүүлэх.

- Байгууллагын ажилтнуудын нэр, холбогдох утасны дугаар бүхий бүтцийн мэдээлэл, сул орон тооны зар, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг дор хаяж сүүлийн 2 жилийн мэдээлэл байхаар шинэчлэх. Шинэчлэгдсэн хугацааг оруулах. Хэдийгээр дээрх мэдээллүүд сайтад байгаа хэдий ч хэзээ хамгийн сүүлд шинэчлэгдсэн, аль оны мэдээлэл гэдгийг хянах, үнэлэх боломжгүй байна.
- Ёс зүйн дүрэм, ажилтнуудын үндсэн үйл ажиллагааны үзүүлэлт, тайлан, байгууллагаас гаргасан нээлттэй файлуудыг татаж авч, цаашид ашиглах боломжтой форматтай болгох.
- Шууд харилцах чатбот үйлчилгээг цахим

хуудастаа нэвтрүүлэх, мэдээлэлд сэтгэгдэл бичих боломжтой болгох, ил тод байдлыг сайжруулах чиглэлээр онлайн санал хүсэлт авдаг болох гэх зэргээр иргэдтэй харилцах боломжийг нэмэгдүүлэх. Үүнд жил, улирлаар шинжилгээ хийдэг байх. Энэ нь эгэх хариуцлагыг нэмэгдүүлж, мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлнэ.

- Байгууллагын нийгмийн сүлжээ рүү болон бусад холбогдох байгууллага руу холбогдох дамжин орж буй ажиллахгүй байгаа холбоосуудыг засварлах. Албан ёсны ашигладаг социал хуудастайгаа холбох. Ингэснээр хэрэглэгчийн олон төрлийн сувгаас мэдээлэл авах боломжийг бий болгоно.
- Цахим хуудаст хандаж буй хүний тоог өдөр, сар улирал, жилээр харагддаг болгох. Энэ нь мэдээлэл хэр олонд хүрч байгаа, хэр зэрэг хүртээмжтэй байгааг харах боломжийг бий болгоно.

Хавсралт. Нийт үнэлсэн төрийн байгууллагуудын эрэмбэ

Эрэмбэ	Байгууллагуудын нэр	2021 оны Индексийн нэгдсэн оноо	Эрх зүйн орчин	Байгууллагын чадамж	Цахим нээлттэй байдал	2019 оны индекс	Зөрүү
1	Өвөрхангай аймгийн ЗДТГ	0.766	0.631	0.831	0.835	0.769	-0.003
2	Хан-Уул дүүргийн ЗДТГ	0.747	0.631	0.810	0.799	-	-
3	Сангийн яам	0.724	0.631	0.935	0.605	0.732	-0.008
4	Өмнөговь аймгийн ЗДТГ	0.720	0.631	0.718	0.810	0.711	0.009
5	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	0.713	0.631	0.880	0.627	0.753	-0.040
6	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар	0.703	0.631	0.678	0.799	0.694	0.009
7	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар	0.698	0.631	0.852	0.610	0.465	0.233
8	Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар	0.696	0.631	0.880	0.576	0.674	0.022
9	Цагдаагийн ерөнхий газар	0.692	0.631	0.808	0.636	0.410	0.281
10	Нийслэлийн онцгой байдлын газар	0.688	0.631	0.640	0.793	0.626	0.062
11	Ус Сувгийн Удирдах Газар	0.686	0.631	0.850	0.576	-	-
12	Баянзүрх дүүргийн ЗДТГ	0.685	0.631	0.833	0.590	0.612	0.073
13	Барилга, хот байгуулалтын яам	0.684	0.631	0.915	0.505	0.517	0.167
14	Монголбанк	0.680	0.631	0.711	0.697	0.719	-0.039
14	Булган аймгийн ЗДТГ	0.680	0.631	0.789	0.619	0.637	0.043
15	Дархан-Уул аймгийн ЗДТГ	0.673	0.631	0.636	0.751	0.733	-0.060
16	Багануур дүүргийн ЗДТГ	0.670	0.631	0.686	0.692	0.580	0.090
16	Авилагатай тэмцэх газар	0.670	0.631	0.958	0.420	0.688	-0.018
17	Орхон аймгийн ЗДТГ	0.661	0.631	0.642	0.709	-	-
18	Хөвсгөл аймгийн ЗДТГ	0.660	0.631	0.805	0.543	0.582	0.078
19	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам	0.658	0.631	0.906	0.436	0.624	0.034
20	Санхүүгийн зохицуулах хороо	0.657	0.631	0.675	0.664	0.636	0.021
21	Татварын ерөнхий газар	0.654	0.631	0.884	0.446	0.673	-0.019
21	Налайх дүүргийн ЗДТГ	0.654	0.631	0.745	0.585	0.678	-0.024
22	Зам, тээврийн хөгжлийн яам	0.651	0.631	0.754	0.567	0.600	0.051
23	Сонгуулийн ерөнхий хороо	0.647	0.631	0.554	0.755	0.516	0.131
24	Архивын ерөнхий газар	0.645	0.631	0.742	0.561	0.504	0.141
25	Иргэний нисэхийн ерөнхий газар	0.639	0.631	0.733	0.552	0.629	0.010

26	Сонгинохайрхан дүүргийн ЗДТГ	0.639	0.631	0.468	0.817	-	-
27	Байгал орчин аялал, жуучлалын яам	0.638	0.631	0.880	0.402	0.556	0.082
28	*Хөдөлмөр халамж үйлчилгээний ерөнхий газар	0.635	0.631	-	0.638	0.636	-0.001
29	Баянгол дүүргийн ЗДТГ	0.625	0.631	0.570	0.673	0.620	0.005
29	Батлан хамгаалах яам	0.625	0.631	0.676	0.567		
30	*Нийслэлийн шинжлэх ухаан, үйлдвэрлэл иновацийн газар	0.620	0.631	-	0.609	0.633	-0.013
31	Говьсүмбэр аймгийн ЗДТГ	0.618	0.631	0.596	0.626	0.558	0.060
32	Засгийн газрын хэрэг эрхлэх газар	0.616	0.631	0.963	0.253	-	-
32	Төрийн худалдан авах ажиллагааны газар	0.616	0.631	0.741	0.475	-	-
33	Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам	0.615	0.631	0.454	0.759	0.000	0.615
34	Эрүүл мэндийн яам	0.613	0.631	0.536	0.671	0.667	-0.054
35	Үндэсний хөгжлийн газар	0.608	0.631	0.568	0.626	0.580	0.028
36	Хууль зүй, дотоод хэргийн яам	0.606	0.631	0.564	0.624	0.568	0.038
37	*Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар	0.603	0.631	-	0.575	-	-
37	Ховд аймгийн ЗДТГ	0.603	0.631	0.713	0.464	0.465	0.138
38	Хэнтий аймгийн ЗДТГ	0.602	0.631	0.674	0.500	0.658	-0.056
39	*Боловсрол, шинжлэх ухааны яам	0.600	0.631	-	0.569	0.639	-0.039
40	Биеийн тамир, спортын улсын хороо	0.598	0.631	0.704	0.458	0.526	0.072
41	*Мэргэжлийн хяналтын ерөнхий газар	0.597	0.631	-	0.563	0.602	-0.005
42	Төрийн албаны зөвлөл	0.596	0.631	0.241	0.915	0.486	0.110
42	*Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар	0.596	0.631	-	0.560	0.554	0.042
43	*Оюуны өмчийн газар	0.594	0.631	-	0.557	-	-
44	Үндэсний статистикийн хороо	0.593	0.631	0.754	0.393	0.664	-0.071
45	*Стандарт, хэмжил зүйн газар	0.592	0.631	-	0.552	0.569	0.023
46	Увс аймгийн ЗДТГ	0.591	0.631	0.839	0.302	0.664	-0.073
47	*Соёлын яам	0.585	0.631	-	0.539	-	-
47	*Үндэсний аудитын газар	0.585	0.631	-	0.538	0.601	-0.017
48	Баян-Өлгий аймгийн ЗДТГ	0.579	0.631	0.522	0.583	-	-
49	Эрчим хүчний яам	0.575	0.631	0.584	0.509	0.000	0.575
50	Говь-Алтай аймгийн ЗДТГ	0.572	0.631	0.475	0.609	0.695	-0.123
51	*Нийгмийн даатгалын ерөнхий газар	0.569	0.631	-	0.506	-	-

52	Завхан аймгийн ЗДТГ	0.563	0.631	0.619	0.438	0.540	0.023
53	Ашигт малтмал, газрын тосны газар	0.558	0.631	0.543	0.499	0.718	-0.160
54	*Жижиг, дунд үйлдвэрийн газар	0.549	0.631	-	0.467	-	-
54	*Үндэсний геологийн алба	0.549	0.631	-	0.467	-	-
55	*Төрийн тусгай хамгаалалтын газар	0.545	0.631	-	0.459	-	-
56	*Гадаад харилцааны яам	0.538	0.631	-	0.444	0.597	-0.060
57	Гаалийн ерөнхий газар	0.537	0.631	0.646	0.333	0.715	-0.178
58	*Зэвсэгт хүчний жанжин штаб	0.535	0.631	-	0.439	-	-
58	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар	0.535	0.631	0.695	0.278	0.614	-0.079
59	Баянхонгор аймгийн ЗДТГ	0.531	0.631	0.529	0.432	0.534	-0.003
60	Дорнод аймгийн ЗДТГ	0.529	0.631	0.364	0.591	0.413	0.116
61	Архангай аймгийн ЗДТГ	0.525	0.631	0.494	0.449	0.636	-0.111
62	*Соёл урлагийн газар	0.524	0.631	-	0.416	0.515	0.008
63	*Хил хамгаалах ерөнхий газар	0.521	0.631	-	0.411	0.573	-0.052
64	*Тагнуулын ерөнхий газар	0.509	0.631	-	0.387	-	-
64	*Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар	0.509	0.631	-	0.386	0.597	-0.089
65	Цаг уур, орчны шинжилгээний газар	0.507	0.631	0.589	0.300	0.528	-0.021
65	Гадаадын иргэн, харьяатын газар	0.507	0.631	0.317	0.572	0.652	-0.145
66	Дорноговь аймаг ЗДТГ	0.501	0.631	0.602	0.269	0.670	-0.169
66	Дундговь аймгийн ЗДТГ	0.501	0.631	0.230	0.641	0.774	-0.273
67	Улаанбаатар хотын захирагчийн алба	0.497	0.631	0.190	0.669	0.653	-0.156
68	Мал эмнэлгийн ерөнхий газар	0.490	0.631	0.440	0.398	0.528	-0.038
69	Сэлэнгэ аймгийн ЗДТГ	0.489	0.631	0.425	0.410	0.634	-0.145
69	Төв аймгийн ЗДТГ	0.489	0.631	0.313	0.522	0.482	0.007
70	Сүхбаатар дүүргийн ЗДТГ	0.479	0.631	0.149	0.656	0.616	-0.137
71	Багахангай дүүргийн ЗДТГ	0.456	0.631	0.228	0.508	0.619	-0.163
72	Хүний эрхийн үндэсний комисс	0.455	0.631	0.442	0.292	0.672	-0.217
73	Улсын бүртгэлийн ерөнхий газар	0.450	0.631	0.228	0.490	-	-
74	Сүхбаатар аймгийн ЗДТГ	0.425	0.631	0.188	0.455	0.583	-0.158

³Байгууллагын чадавхыг үнэлэхийн тулд тухайн байгууллагын холбогдох албан хаагчдаас үнэлгээнд хамрагдах зөвшөөрөл авсан. Үнэлгээнд хамрагдаагүй байгууллагыг * тэмдэглэв.